

“Мандалговь-Импекс” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл

2018-04-24

Улаанбаатар хот

“Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018-04-24-ны өдрийн 15:00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд хуралдлаа. Хурлыг Д.Мөнхсайхан даргалав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Монгол улсын компанийн тухай хуульд заасан дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг товолж өнөөдөр хурлаа хийх гэж байна. Бүх БДК-уудад хурлын материалыг хүргүүлсэн ба олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хуульд заасан хугацаанд зарыг тавьсан. Одоо хурлын дэгийг танилцуулъя. Та бүхэнд хурлын дэгийн талаар санал хүсэлт байна уу?

Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хурлын дэгийг баталлаа. Нарийн бичгийн дарга С.Батбилэг хурлын ирцийг танилцуулав.

С.Батбилэг: “Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцааны 52612 ширхэг хувьцааг эзэмшигч 9 хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирсэн ба 73,71 хувийн ирцтэй байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан үндэслэлээр хурлын ирц хангагдсан байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

-Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

-Компанийн ТУЗ-ийн 2017 оны тайлан

-Аудитын хорооны тайлан

-ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Хурлын дэгийн дагуу компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг Ө.Будханд танилцуулна гэв.

Ө.Будханд: Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Тайлантай холбогдуулж асуух тодруулах зүйл байвал асууя гэв.

А.Цэцэгдэлгэр: Жилээс жилд үйл ажиллагаа чинь муудаад байна уу даа?

Ө.Будханд: Орон нутгийн хүн амын амьжиргаа муу, хүн ам цөөн, зах зээл байхгүй, хөрөнгө оруулалт хийгээд тэр нь эргээд гараад ирнэ гэхэд хэцүү. Байдал үнэхээр хэцүү байна. Жил болгон л энэ талаар ярьдаг шийдсэн дорвитой зүйл алга, хийх гэхээр эдийн засгийн байдал маш муу байна.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Хурлын дэгийн дагуу одоо ТУЗ-ийн тайланг сонсоё.

Ө.Будханд: Компанийн ТУЗ-ийн 2017 оны тайланг танилцуулав.

А.Цэцэгдэлгэр: Одоо хэдэн хүн ажиллаж байгаа юм бэ?



Ө.Будханд: Одоо 5 хүн л ажиллаж байгаа. Ямар нэгэн өр ширний асуудалгүй байна. Хөрөнгийн биржийн хуримтлагдсан өрийг өгсөн. Үнэндээ орлого муу учраас зарим зардалыг өөрөөсөө гаргадаг. Одоо гаргах гээд ч гаргах чадал байхгүй болж байна.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Аудитын дүгнэлтийг А.Цэцэгдэлгэр танилцуул гэв.
А.Цэцэгдэлгэр: Аудитын дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Асууж тодруулах зүйл байвал асууя гэв.

А.Цэцэгдэлгэр: Будханд хувийхаа зүгээс өвөл нүүрс авч өгдөг юм байна. Зарим нэг зардалыг дан хувиасаа гаргадаг юм банья. Яагаад баланс тайлан дээр үүнийгээ тусгахгүй байна. Танай тайланг харахад орлого зарлага яг тэнцүү байна..

Ө.Будханд: Тиймээ, орон тооны нягтлан байхгүй нэг хүн гуйж тайлангаа гаргуулдаг. Ёстой үнэхээр хэцүү байна. Энэ компаний асуудлыг нэг тийш нь шийдэж өгмөөр байна.

Д.Хуушаан: Сахилга хариуцлага тоцдог болмоор байна. Хуучнаар явдаг системийг сэргээх хэрэгтэй. Цэцэгдэлгэр үүнийг удирдан зохион байгуулж ажил хэрэг болгох хэрэгтэй.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: За одоо дэгийн дагуу санал хураах үйл ажиллагаа явуулъя.

Н.Болормаа: Санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төслийг танилцуулав.

1. Саналын хуудсаар компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн байна.

2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Д.Ганболд, Д.Хуушаан, Д.Мөнхсайхан, Ч.Тогтохбаяр, Ө.Будханд, А.Цэцэгдэлгэр 5845 ширхэг санал буюу 100 хувь, хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Гантулга, С.Дарханбаатар С.Содбаатарт 5845 ширхэг санал буюу 100 хувь тус тус санал авав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: “Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслүүдийг танилцуулж баталлаа.

1. Тогтоол №1 Тайлан батлах /2017 оны үйл ажиллагааны тайлан, Аудитын хорооны тайлан, ТУЗ-ийн тайлан/

2. Тогтоол №2 ТУЗ-ийн гишүүдийг батлах

Хурлыг 16 цагт хаав.

Хянасан: Хурлын дарга

Д.Мөнхсайхан

Тэмдэглэл хөтөлсөн:

С.Батбилэг